

**ӨВ. БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СИСТЕМЧЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ,
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААРХ МЭДЭЭ
/2022 оны 2 дугаар улирал/**

2022.06.22

Өвт

№	Ажлын чиглэл	Үзүүлэлт	Сум, байгууллага /тоон үзүүлэлт/	
1	Хууль тогтоомжийн системчлэл, мэдээлэл	Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн актын тоо	14632	
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санг шинээр баяжуулсан эрх зүйн актын тоо	450	
		Системчлэл хийсэн хууль тогтоомж		
		Өөрчлөлт хөдөлгөөн хийсэн зүйл, заалтын тоо	20/40	
		Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	200
			Байгууллага	7
		Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн гар сангаас лавлагаа мэдээлэл өгсөн	Иргэд	10
Байгууллага	5			
2	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянах	Хянаж санал өгсөн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж /гарсан захирамж/	А захирамж 108, Б захирамж 15 нийт 123 шийдвэр гарсан.	
		Үүнээс захиргааны хэм хэмжээ тогтоосон захирамж	Хууль зүйн яаманд хянуулж бүртгүүлсэн	
			Хууль зүйн яамнаас дүгнэлт гаргаж буцаасан	
3	Эрх зүйн сургалт, сурталчилгаа	Зохион байгуулсан эрх зүйн сургалт, хэлэлцүүлэг	18	
		Үүнээс сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан хүний тоо	2500	
		Зохион байгуулсан эрх зүйн сурталчилгаа	88	
		Боловсруулсан гарын авлага, сургалт, сурталчилгааны материал	5000ш	
		Радио, телевизийн нэвтрүүлэг	-	
		Сонин хэвлэлээр сурталчилсан	-	
		Бусад /		

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

МЭДЭЭ ГАРГАСАН: ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН
ЭРХ ЗҮЙН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ИЛТГЭХ ХУУДАС
/2022 оны 2 дугаар улирал/

2022 оны 06 дугаар сарын 22

ӨВТ

Удирдлага зохион байгууллалт болон төрийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлсэн сургалт, сурталчилгааны чиглэлээр

Бат-Өлзий сумын “Эрх зүйн сургалт, сурталчилгааны баг” иргэдэд хууль тогтоомж, хуулинд орсон нэмэлт өөрчлөлт, танин мэдэхүйн чиглэлээрх мэдээллийг тухай бүр өгч ажилладаг. Мөн Бүх нийтийн эрх зүйн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн сумын эрх зүйн хөтөч Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудас шинээр нээн ажиллуулж иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх хуулийн сурталчилгааг байнга нийтэлж, олон хүнтэй пэйж гүүппрүү пост түгээж байна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн шинэчилсэн хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчилах ажлын хүрээнд хуулийн гарын авлагыг төрийн байгууллагуудын албан хаагчдын дундын гүүппээр дамжуулан 240 албан хаагчид, иргэдэд хууль журмыг таниулах хүрээнд Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар сурталчилан ажилласан. Мөн гарын авлага хэлбэрээр гарган төрийн албан хаагчдад сурталчилсан.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дахь заалтын дагуу Бат-Өлзий сумын 6 багийн иргэдийн Нийтийн хурлын 1, 2 дугаар улирлын хуралдааныг товын дагуу 2022 оны 4, 6 дугаар саруудад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, ЗДТГазар хамтран зохион байгуулж, багийн хурлуудад нийт 1185 иргэн оролцлоо.

Багийн иргэдийн Нийтийн хурлуудад сумын удирдлагууд болон ЗДТГ-ын мэргэжилтнүүд хууль эрх зүй, хөдөлмөр халамж үйлчилгээ, эрүүл мэнд, нийгмийн даатгал, иргэний бүртгэл, татвар, байгаль орчин, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч, шторк, 3500 ш боршур гарын авлага тараан, зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.



Багийн хурлын зурагнаас



Бэлтгэсэн гарын авлага, материалууд






2022 оны 05 дугаар сарын 05-нд Бат-Өлзий сумын ИТХурлаас багийн иргэдийн Нийтийн хурлын зөвлөлийнхөнд Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай шинэчилсэн хуулийн талаар 36 хүнд сургалт зохион байгуулсан.



Улсын хэмжээнд 4 аймгийн 5 сумдад Орчны бүсийн зээл, эргэлтийн сан төсөл хөтөлбөр хэрэгжиж байгаа учраас орчны бүсэд нутагладаг айл өрхүүдэд бага хүүтэй зээл олгож эхэлсэн. Монгол Улсын тусгай хамгаалалтай газар нутгийн орчны бүсийн малчдын амьжиргааг дэмжих, бэлчээрийн доройтлыг бууруулах, нөхөн сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилготой орчны бүсийн малчдад хөнгөлөлттэй зээл олгох зээлийн сан юм. Энэхүү зээлийн талаар БИНХ-аар иргэдэд мэдээлэл өглөө. Өмнөх онд 35 өрх, 2022 онд 7 өрх тус зээлд хамрагдаад байна.



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 77 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Иргэдийн дуу хоолой ба түүний үр нөлөө” хэлэлцүүлгийг сумын Цагдаагийн тасгийн стандартын хэрэгжилтэд үнэлгээ өгөх ажлыг сумын төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, Бүрэгтий, Хүйтэн булаг, Өвт багуудийн нийт 556 иргэдийг хамруулан зохион байгуулав.



2022 оны 3 дугаар сарын 25-30-ны өдрүүдэд сумын ИТХурал нь Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран сумын иргэдийн Төлөөлөгчдийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 27 төлөөлөгч хамрагдсан.



Бат-Өлзий суманд 2022 оны 5 дугаар сард 13-нд аймгийн бүх сумдын ЗДТГ-ын дарга болон Санхүү албаны дарга нарт, Төв аймгийн ЗДТГ-ын хамт олонд улс, орон нутгийн төсөв болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээнд хяналт үнэлгээ, шинжилгээ хэрхэн хийх тухай “Сайн туршлага” сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулав.

Сургалтад 60 хүн хамрагдсан.



2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр, 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын Шүүх нүүдлэн ирж шүүн таслах ажиллагааг иргэдэд ойртуулах болон эвлэрүүлэн зуучлах ажиллагааг таниулан сурталчлах, иргэдийн хэрэг маргаанаа эвлэрүүлэн зуучлалын ажиллагаагаар шийдвэрлүүлэх хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор "Нээлттэй шүүх" арга хэмжээг ЗДТГазартай хамтран зохион байгууллаа.



Ажиллах хугацаандаа 8 нэхэмжлэлийг хүлээн авч, 16 иргэний хэрэгт гэрч асуух болон бусад ажиллагааг хийн хэргийг хянан шийдвэрлэж, 100 гаруй иргэнд шүүхэд нэхэмжлэл гаргахад шаардагдах баримт материалын талаарх мэдээллийг өгч ажилласан.



Мөн тус сумын 6 шүүхийн иргэдийн төлөөлөгч нарт ганцаарчилсан болон хамтарсан сургалтыг зохион байгуулж, Засаг даргын тамгын газарт байрлах "Шүүхийн мэдээллийн самбарт" иргэдэд зориулсан мэдээллийг шинэчиллээ.

2022 оны 05 дугаар сарын 04-нд Хархорин сум дахь Прокурорын газраас Бат-Өлзий сумын Төрийн албан хаагчдад Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, Прокурорын хууль, тогтоомж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомжийни талаар мэдээлэл, зөвлөгөө өглөө. Сургалт, мэдээлэлд 30 албан хаагч хамрагдав.



2022 оны 05 дугаар сарын 25-нд ЗДТГазрын хууль, эрх зүйн мэргэжилтэн Г.Доржханд төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, архив, бичиг хэргийн ажилтнуудад “Албан хэрэг хөтлөлтийн стандарт” сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 12 албан хаагч хамрагдсан.



Засаг даргын Тамгын газар нь гадна талбайдаа лэд дэлгэц сууриллуулж, Засаг даргын Тамгын газар болон бусад төрийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ, мэдээлэл, шторк, зар сурталчилгаа, хууль тогтоомжийн мэдээллийг дэлгэцээр дамжуулан иргэдэд түгээн ажиллаж байна.



2022 оны 05 дугаар сарын 09-нд Татварын улсын байцаагч, Нийгмийн даатгалын байцаагч нар хамтран суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжийн дарга, эрхлэгч, нягтлан бодогч нарт Нийгмийн даатгалын тухай хууль, хуулинд орсон өөрчлөлт, тоон гарын үсэг олгох талаар сургалт зохион байгуулсан. Сургалтанд нийт 28 иргэн хамрагдсан.

Мөн аж ахуйн нэгж, иргэдэд хамааралтай хууль тогтоомжоор (Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татвар, нийгмийн даатгал, Зөрчлийн тухай хууль) гарын авлага бэлтгэн тараасан.



2022 оны 05-р сарын 26, 27-нд аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсээс “Дотоодын хяналт, шалгалт, сургалт, сурталчилгааны аян”-ныг суманд зохион байгуулж, тус аяны хүрээнд аж ахуй нэгж байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч, иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжид орсон өөрчлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан гаргахад анхаарах асуудал, цахим эмнэлгийн хуудас болон цахим дэвтрийн талаар сургалт зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгч зарим иргэдийн ажилласан жилийг тооцож иргэд, даатгуулагчдад нийгмийн даатгалын аппликейшнийг суулгаж, заавар зөвлөмж өгч ажилласан. Сургалтанд нийт 56 иргэн хамрагдсан.

Мөн хамгийн олон жил нийгмийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч, хамгийн олон малчин даатгуулагч нийгмийн даатгалд хамруулсан багийн Засаг дарга шалгаруулж батламж гардуулсан.



Бат-Өлзий суманд 2022 оны 05 дугаар сарын 23-нд Өвөрхангай аймгийн Хөдөлмөр, халамжийн газраас байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг зохион байгуулсан. Өдөрлөгт 90 гаруй иргэн оролцож хөдөлмөр эрхлэлт болон Ниймийн халамжийн хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан байна. 120 гаруй гарын авлага тараасан.



Бат-Өлзий сумын ЗДТГазар, ХХҮГазар, “Эм эс девелопмени консалтинг” ХХК-ний дэргэдэх мэргэжил сургалтын төв хамтран 2022 оны 05 дугаар сарын 25-27-ны хооронд тус сумын хүнсний эрхийн бичиг авдаг 49 иргэнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Хөдөлмөрт бэлтгэх” хөтөлбөрийн сургалтыг зохион байгуулж, аж ахуй эрхлэх батламжийн гэрчилгээ олгосон.



2022 оны 04 дүгээр сарын 15-нд “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, Нээлтийн арга хэмжээнд ирсэн иргэдэд Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Зөрчлийн тухай хууль тогтоомжууд болон мод тарих аргачлалын талаар мэдээлэл өгч, гарын авлагаа тараасан. Нээлтийн арга хэмжээнд 200 гаруй иргэн оролцлоо.



2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ЗДТГазар, ЕБС, СӨББ, Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ЕБС-ийн ахлах дунд ангийн 178 сурагчийг хамруулан архи согтууруулах ундаа, утаат болон электрон тамхины хор уршгийн талаар “Эерэг хандлага ба хорт зуршил” сургалт, хэлэлцүүлэг, 98 эцэг, эхэд “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, Гэр бүлийн харилцаа хандлага, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.



Архины хамааралтай, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нарт гэр бүлийн харилцаа, гэр бүлийн үнэ цэнэ, архины хор хөнөөл, гэр бүлийн тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, гэр бүлийн боловсрол олгох шторк, мэдээ мэдээллийг Бат-Өлзий урьдчилан сэргийлэх ажил, Бат-Өлзий сумын нэгдсэн группээр дамжуулан иргэдэд хүргэж, 158 иргэнд гарын авлага тараач зөвлөгөө зөвлөмж өгсөч .

Бат-Өлзий...
53,578 MEMBERS
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН НЭГДСЭН ГРУПП ✓

Цэрэндулам Ганхуяг
Just now
❤️❤️❤️ ХАЙРАА
❤️❤️❤️ ХАЙРЛАЯ
😬😬😬 ХАНДЛАГАА ӨӨРЧИЛЬЕ
😬😬😬 ХАМТДАА ҮЛГЭРЛЭЕ

Цэрэндулам Ганхуяг
4 d
Гэр бүлийн хүчирхийлэл гэж юу вэ?
Хүчирхийллийн 4 хэлбэр

Цэрэндулам Ганхуяг
20 h
#1 ХҮҮХЭД ХҮМҮҮЖҮҮЛЭХ ХЭВШМЭЛ ХАНДЛАГАА ӨӨРЧЛӨЕ!
Хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь ухамсарт, санаатай үйлдэл юм. Яг одооноос хүүхдийг ялгаварлан гадуурхаж, зүй бус харьцсан аливаа үйлдлийг "уламжлал" гэх нэрээр өөгшүүлэхээ зогсооцгооё!
Хүүхэдтэй зүй бус харьцах нь хүүхдийн эрүүл мэнд, бие махбод/оюун санааны хөгжил, төлөвшилт болон өөртөө итгэх итгэл, сурлага, хүмүүжилд сөргөөр нөлөөлдөг тул насанд хүрэгчид өөрсдийн үг, үйлдлээ алхам тутамдаа анхаараарай !!
ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ НЬ ГЭМТ ХЭРЭГ !!
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл/шийтгэлийн хэлбэрүүд: ✗Бие махбодын ✗Сэтгэл санааны ✗Бэлгийн ✗Үл хайхрах явдал юм.

Бат-Өлзий...
Like Comment Share
Write a comment...

Цэрэндулам Ганхуяг
1 2 3
1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ
2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ
3. ХАМТДАА ҮЛГЭРЛЭЕ

Цэрэндулам Ганхуяг
4 11% 17:00
MN MobilCom 41% 11:41

2022 оны 05 дугаар сарын 02-ний өдөр “Үжин” төв, сумын ЗДТГазар хамтран “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийг чадавхжуулах нь” сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд сумын хүүхдийн байгууллагын дарга, эрхлэгч, анги удирдсан багш нар, нийгмийн ажилтнууд, багийн Засаг дарга нар нийт 68 хүн хамрагдаж, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэх талаар их зүйлийг ойлгуулсан үр дүнтэй сургалт болсон.

Боловсрол, эрүүл мэнд, соёлын салбарын чиглэлээр зохион байгуулсан сургалт, сурталчилгаа

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагууд эцэг, эхчүүдийн дундын группд боловсролын чиглэлээр явуулж буй үйл ажиллагаа болон мэдээ мэдээлэл, цахим сургалт, зөвлөгөө, зөвлөмж зэргийг бэлтгэн тогтмол мэдээлсэн. Мэдээлэл сурталчилгаанд давхардсан тоогоор 1500 гаруй иргэн хамрагдсан.

2022 оны 2 улиралд Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 20 бүлгийн 630 эцэг, эхэд ЕБС-ийн нийгмийн ажилтан, анги удирдсан багш нар хамтран “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн сургалтыг зохион байгууллаа.

2022 оны 05 дугаар сарын 20-нд Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөх сурагчдын эцэг, эхчүүдэд “Мэргэжил хэрхэн зөв сонгох вэ” сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 83 эцэг, эх хамрагдаж мэргэжил сонголтын талаар мэдлэг, мэдээлэлтэй болсон



2022 оны 04 дүгээр сарын 25-нд ORBIS хараа сайжруулах олон улсын төслийн хүрээнд ЕБСургууль, БОЭТ-ийн нүдний их эмчтэй хамтран нүдний хараа сул 56 хүүхдийн эцэг, эхэд сургалт явуулж, зөвлөгөө өгсөн.



2022 оны 06 дугаар сарын 15-нд Орон нутгийн өсвөр үеийнхэнд хувь хүний ур чадвар, энтрепренершип боловсрол олгох сургалтад хамрагдаж төгссөн сурагчдын эцэг, эхчүүдийн тайлант хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт 20 хүн хамрагдсан.



2022 оны 05 дугаар сарын 09-нд 2-р цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын баг эцэг, эхчүүддээ “Хүүхэд хамгаалал”-ын талаар сургалт зохион байгууллаа. Сургалтад 60 эцэг, эх хамрагдлаа.



2022 оны 04 дүгээр сарын 25-нд томуу, томуу төст өвчин, салхин цэцэг өвчин ихэссэнтэй холбоотой цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг, эхчүүдэд СӨББ, Эрүүл мэндийн төв

хамтран сургалт, зөвлөгөө сургалт, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Сургалт мэдээлэлд нийт 180 хүн оролцсон .

Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан эрүүл мэндийн салбарын мэдээлэл, сурталчилгааг олон нийтийн сүлжээгээр тогтмол мэдээлсэн.

ЭМТөвд хэвтэн эмчлүүлсэн нийт 250 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгох болон зохистой хооллолт, идэвхтэй хөдөлгөөн гэх мэт сэдвүүдээр тогтмол мэдээлэл өгч ажилласан.

ЭМДаатгалаар үйлчлүүлэгч 400 иргэнд эмийн зохистой хэрэглээ сэдвээр мэдээлэл өгсөн.

Эрүүл мэндийн чиглэлээ 15 удаагийн сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдээлэл байршуулсан ба хандалтын тоо 3423. Нийт 500 ширхэг зөвлөмж хийж, тараасан.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг Бат-Өлзий сумын Урьдчилан сэргийлэх цахим сүлжээгээр иргэдэд түгээж ажилласан. Хандалт 1325 хүнд хүрсэн.

2022 оны 2 дугаар улиралд эрх, зүйн сургалт, сурталчилгааг 18 удаа явуулж, 24 сэдвээр 5000 гаруй зөвлөмж, гарын авлага, тараах материал иргэдэд тарааж ажилласан байна.

БАТАЛГААЖУУЛСАН: ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.ДОРЖХАНД

Сумын ЗДТГ-ын ХААТасаг, Мал эмнэлгийн тасгаас тайлант хугацаанд Мал, амтны эрүүл мэндийн тухай хууль, мал, эмнэлгийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх зорилго, зорилтуудыг танилцуулан малчдын санал хүсэлтийг хүлээн авч, мэргэжилтнүүдийн бэлтгэсэн 9 төрлийн гарын авлагыг олшруулан 1099 ширхэгийг тараан малчдын гар дээр хүргэсэн. Үүнд: “Халдваргүй өвчин”, “Малын эмийн зохистой хэрэглээ”, “Шимэгчтэх өвчин” бусад гарын авлага шторк бэлдтгэн МЭТ-н цахим хаягаар дамжуулан нийтэд мэдээлж ажиллаа.



1, 2, 3, 4, 5, 6 дугаар багуудийн хурлуудад Малчин, мал бүхий иргэдэд Мал, амтны эрүүл мэндийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар болон мал, амтны өвчний хор хохиролын талаар мэдээ, мэдээллийг өгч, гарын авлага тараасан.

